



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/143

Мөрөн сум

Төв, хангайн бүсийн аварга тогооч,
зөөгч шалгаруулах ур чадварын уралдаан-2023
урлаг, спортын наадам зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын 5/К, Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар хуралдааны 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймаг 2023 оныг “Хөвсгөлд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан аялал жуулчлал, аймгийн зочлох үйлчилгээний салбарын хөгжлийг дэмжих зорилгоор “Төв, хангайн бүсийн аварга тогооч, зөөгч шалгаруулах ур чадварын уралдаан”-ыг 2023 оны 04 дүгээр сарын 27-29-ний өдрүүдэд Мөрөн суманд зохион байгуулсугай.


2. “Төв, хангайн бүсийн аварга тогооч, зөөгч шалгаруулах ур чадварын уралдаан”-ы бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Тус арга хэмжээнд орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хоол үйлдвэрлэл үйлчилгээний газар, аялал жуулчлал, амралт сувиллын газруудыг өргөн хүрээтэй хамруулж, ажиллахыг ажлын хэсгийн ахлагч аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-эрдэнэ), Байгаль орчин аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр), Боловсрол шинжлэх ухааны газар (Ц.Ганзориг), аймгийн Хоол үйлдвэрлэгчдийн холбоо (Л.Оюун-Эрдэнэ) нарт тус тус даалгасугай.

4. Арга хэмжээг зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагааны зардалд 7.818.000 (Долоон сая найман зуун арван найман мянга)-н төгрөгийг “Хөвсгөлд зочлох жил” нэрлэсэн жилийн арга хэмжээний зардлаас зарцуулахыг ерөнхий нягтлан бодогч Л.Батжаргалд зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА




Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2023

6717010533

Аймгийн Засаг даргын 2023 оны 04
дүгээр сарын ... -ний өдрийн А/...
захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

“Хөвсгөлд зочлох жил”-ийн ажлын хүрээнд “Төв, Хангайн бүсийн аварга тогооч, Зөөгч шалгаруулах ур чадварын уралдаан-2023”, Урлаг спортын наадмыг 2023 оны 04 дүгээр сарын 27-29-ний өдрүүдэд Мөрөн суманд зохион байгуулах ажлын хэсэг Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Мөнгөн-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүдэд: Б.Оюунтуяа (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Батбилгүүн (Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Я.Эрхэмбаяр (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Ц.Ганзориг (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

Ш.Даваадамдин (Соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

П.Мөнхжаргал (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Н.Баатар-Очир (Политехник коллежийн захирал)

П.Амарбаясгалан (Монголын тогоочдын холбооны төвийн бүсийн дарга)

Л.Оюун-Эрдэнэ (Аймгийн Тогооч нарын холбооны тэргүүн)

Нарийн бичгийн дарга:
Д.Чинзориг

(Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

----- оОо -----